



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2021 оны 06 сарын 11 өдөр

Дугаар A/34

Улаанбаатар хот

**Заавар батлах тухай**

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрийн зорилт 6 (№3.6.1.1), Төвийн хөгжил хөтөлбөрийн зорилт 1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн удирдлагын зөвлөлийн 2021 оны 06 сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Шувууны тандалт судалгааны заавар”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд тандалт шуурхай удирдлагын албаны дарга /Д.Отгонбаяр/, Лавлагаа лабораторын албаны дарга /Д. Ганболд/, Аймаг, нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвүүдийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чанарын албаны дарга /У.Нармандах/, Дэд захирал /Б.Амгаланбаяр/-д үүрэг болгосугай.

4. Заавар батлагдсантай холбогдуулан Төвийн захирлын 2013 оны А/50 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЦОГБАДРАХ

Байгууллагын нэр: Зоонозын өвчин  
судлалын үндэсний төв

Баримт бичгийн нэр: Шувууны тандалт  
судалгааны заавар

Баримт бичгийн огноо: 2021.05.19

Баталсан, зөвшөөрсөн актын дугаар:

Төвийн ерөнхий захирлын 2021 оны 06 дугаар сарын  
...11...-ны өдрийн А/34... дугаар тушаалын хавсралт

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЦОГБАДРАХ

Хянасан:

НЭМТШУА-ны дарга  Д.Отгонбаяр

Боловсруулсан:

Амьтан судлагч:



С.Мөнгөнбагана

Шимэгч судлагч:



Ц.Ганхуяг

Амьтан судлагч:



Д.Батжав

2021 он

## АГУУЛГА

|                                                                          |    |
|--------------------------------------------------------------------------|----|
| НЭГ. ҮНДЭСЛЭЛ .....                                                      | 4  |
| ХОЁР. НЭР ТОМЬЁО .....                                                   | 4  |
| ГУРАВ. ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ .....                                       | 5  |
| ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ .....                                     | 5  |
| 4.1.    Зоонозын өвчин судлалын үндэсний төв .....                       | 5  |
| 4.2.    Орон нутгийн Зоонозын өвчин судлалын төв .....                   | 6  |
| ТАВ. АЖИЛЛАХ БҮРЭЛДЭХҮҮН, ШААРДЛАГАТАЙ БАГАЖ ХЭРЭГСЭЛ .....              | 6  |
| ЗУРГАА. ТАНДАЛТ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ .....                                | 6  |
| 6.1.    Идэвхигүй тандалт судалгаа .....                                 | 6  |
| 6.2.    Идэвхитэй тандалт судалгаа .....                                 | 7  |
| 6.2.2.1.    Усны шувууны тандалт судалгаа .....                          | 7  |
| 6.2.2.2.    Махчин шувуудын тандалт судалгаа .....                       | 8  |
| 6.2.2.3.    Тэжээвэр шувууны аж ахуйд тандалт хийх .....                 | 8  |
| ДОЛОО. ҮЙЛ АЖИЛЛАГАА .....                                               | 9  |
| 7.1.    Мэдээ цуглуулах, бүртгэх .....                                   | 9  |
| 7.2.    Өвчний сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед авах арга хэмжээ ..... | 9  |
| 7.3.    Шувууг таньж тодорхойлох .....                                   | 11 |
| 7.4.    Тандалт судалгаанд анхаарах зүйл .....                           | 11 |
| НАЙМ. БАРИХ-ТЭМДЭГЛЭХ-ДАХИН БАРИХ .....                                  | 11 |
| 8.2.    Махчин шувуудыг барих арга зүй. ....                             | 12 |
| 8.3.    Усны шувуудыг барих .....                                        | 13 |
| 8.4.    Шувууг тэмдэглэх .....                                           | 13 |
| ЕС. ШУВУУНЫ ҮҮРНЭЭС ШИМЭГЧ ТҮҮХ АРГА ЗҮЙ .....                           | 14 |
| АРАВ. ШУВУУНААС СОРЬЦ АВАХ .....                                         | 14 |
| 10.7.    Дээж авах аргачлал. ....                                        | 15 |
| 10.9.    Дээж хадгалах, тээвэрлэх .....                                  | 16 |
| АРВАН НЭГ. ТАЙЛАН БИЧИХ ДАРААЛАЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА .....               | 17 |
| АРВАН ХОЁР. АШИГЛАСАН НОМ ЗҮЙ .....                                      | 18 |

## **ЗУРГИЙН ТАЙЛБАР**

|                                                                   |    |
|-------------------------------------------------------------------|----|
| Зураг 1 Сүрэг шувуудыг багцлан тоолох .....                       | 7  |
| Зураг 2 Шугаман маршрутын арга .....                              | 8  |
| Зураг 3 Жижиг шувууд барих тор.....                               | 12 |
| Зураг 4 Өгөөш бүхий махчин шувууны урхи.....                      | 13 |
| Зураг 5 Суух суудал, үүрний орчинд байршуулах өгөөшгүй урхи ..... | 13 |
| Зураг 6 Шувуунаас дээж авах арга .....                            | 15 |
| Зураг 7 Шувуунаас цус авах судасны байрлал .....                  | 16 |

## **ХАВСРАЛТ**

|                                                                                               |    |
|-----------------------------------------------------------------------------------------------|----|
| Хавсралт 1 Шувууны томуу өвчний тохиолдол тархалтын мэдээ.....                                | 19 |
| Хавсралт 2 Шувууны тандалт судалгааны бүртгэл .....                                           | 20 |
| Хавсралт 3 Шувууны тандалтын үеэр иргэд, малчидтай уулзаж ярилцсан тухай<br>тэмдэглэл.....    | 31 |
| Хавсралт 4 Шувууны тандалтанд хийсэн газар орны экологийн судалгаа.....                       | 32 |
| Хавсралт 5 Тандалтанд хамрагдах нууруудын цэгийн нэр, код, солбицол .....                     | 33 |
| Хавсралт 6 Тэжээвэр шувуутай айл өрх, албан байгууллагаас авах үнэлгээний хуудас ..           | 52 |
| Хавсралт 7 Шувуунаас цуглуулсан дээжний бүртгэл.....                                          | 53 |
| Хавсралт 8 Яаралтай мэдээлэх хуудас (Олон улсад болон бусад мэргэжлийн<br>байгууллагад) ..... | 54 |

## НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Шувууны томуу нь инфлюенц вирусаар үүсгэгддэг, амьсгалын замын цочмог халдварт өвчин юм. Томуугийн А вирус нь Миксовирусын овог, Ортомиксовирусын язгуурт хамаардаг бөгөөд гадаргуун хоёр уургийн эсрэгтөрөгчийн хэв шинжээр нь гемаглютинин (H)-ын 18, нейраминидаза (N)-ын 11 өөр дэд хэвшилд ангилж үздэг. Томуугийн А хүрээний (Influenza A virus) вирус нь хүн, хөхтөн амьтан, бүх төрлийн тэжээвэр болон зэрлэг шувуудад амьсгалын замын халдварт өвчин үүсгэдэг. Шувууны томуу өвчин (Avian influenza)-д бүх төрлийн тэжээвэр болон зэрлэг шувууд мэдрэг боловч нүүдлийн зэрлэг усны шувууд тэр дундаа нугасны овгийнхон тухайн вирусын байгалийн тээгч эзэн болдог.

Анх 1997 онд шувууны томуугийн вирусийн өндөр хоруу чанар бүхий H5N1 дэд хэвшил нь БНХАУ-ын Гуан-Донг мужид илэрсэн. 2003 оны сүүлчээр зүүн Азийн орнууд, Европ, Ойрхи Дорнодын орнуудад нүүдлийн шувуудаар дамжин тархаж дэлхийн хүн ам, тэжээвэр шувуудын эрүүл мэндэд ноцтой аюул учруулах болсон. 2020 оны 2 дугаар сараас 2021 оны 2 дугаар сарын хооронд Америк, Ази, Европ тивийн нийт 39 улс орны шувууны аж ахуй болон нүүдлийн шувуудын дунд А хүрээний томуугийн 10 дэд хэвшил бүртгэгдээд байна. Нийт тохиолдлын тал хувь нь өндөр хоруу чанарт H5N8 хэвшинж нугас, галуу, тахиа зэрэг шувууны аж ахуйд бусад тохиолдлууд нь зэрлэг шувуудын дунд бүртгэгдсэн байна. Зэрлэг шувууд буюу цахлай, галуу, нугас, хунгийн төрлийн шувууд өвчилсөн ба цөөн тохиолдолд хэрээ, шонхор, тагтаа зэрэг шувууд өртжээ.

Монгол орны нутагт одоогоор 466 зүйлийн шувуу бүртгэгдсэн ба шувуудийн нүүдлийн 4 гол замаар (Зүүн Ази-Австрали, Төв Ази-Энэтхэг, Баруун Ази-Африк, Газар дундын тэнгис-Хар тэнгис) 391 зүйлийн шувууд ирж өндөглөх, зусах болон дамжин нүүдэллэдэг байна.

2003 оноос хойш Монгол оронд нүүдлийн шувуудаас шувууны томуугийн сул хоруу вирусээр (H2N2, H3, H3N8, H4N6, H6N2) үүсгэгдсэн 11, өндөр хоруу вирусээр (H5N6, H5N1, H5) үүсгэгдсэн 12 тохиолдол бүртгэгдээд байна.

Сүүлийн жилүүдэд Монгол оронд шувууны аж ахуй эрхлэгчид нэмэгдэж (нийслэлийн нутаг дэвсгэрт 2020 оны байдлаар 566 мянган тэжээвэр шувууд бүртгэгдсэн), тэжээвэр шувууд нүүдлийн шувуудын амьдрах орчинтой давхцах, халдварт өртөх эрсдэл өндөр болсон.

Зүүн Азийн улс оронд буюу манай орны нүүдлийн усны шувуудын гол өвөлждөг газар нутагт байгаль орчны доройтол, хүн амын хэт өсөлт, цаг уурын дулаарал зэргээс үүдэлтэй шувууны халдварт өвчин шинээр дэгдэх, дахин сэргэх, зөөвөрлөгдөх эрсдэлтэй байна.

Манай оронд томоохон гол, нуурын ойролцоо зусдаг малчдын тоо нэмэгдсэн, дотоодын аялал жуулчлал нэмэгдсэнтэй холбоотой ард иргэд халдварт өртөх эрсдэлийг дагуулж байна.

Иймд зэрлэг шувуудын дундах тандалт судалгааг өргөжүүлэх, ард иргэдийг халдвараас эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх тогтолцоог өргөжүүлэх шаардлагатай байна.

## ХОЁР. НЭР ТОМЬЁО

- 2.1. **Усны шувууд** - ус намгархаг газарт амьдрахад дасан зохицсон шувууд (Галуутны баг /галуу, нугас, хун, анхидал, алаг шунгаач, шумбуур зэрэг 18 төрлийн 37 зүйл/, Гахуунатан /ахууна, шунгуур зэрэг 3 төрлийн 7 зүйл/, Налтан /1 зүйл/, Өрөвтастан /1 төрлийн 2 зүйл/, хотонтон /хотон, халбаган хошуут, дэглэй, дэглий, бухшувуу зэрэг 11 төрлийн 16 зүйл/, Олдойтон /гогой 1 төрлийн 1 зүйл/, Тогоруутан /түнжүүр,

- тогоруу зэрэг 10 төрлийн 19 зүйл/, хиазатан /хавтгаалж, сүвээцагаан, хиазат, ээтэн зэрэг 9 төрлийн 17 зүйл/, хараалжтан / тутгалжин, цууцал, хараалж, элсэг, хөгчүү, цахлай, хараалай зэрэг 25 төрлийн 67 зүйл)
- 2.2. **Суурин шувууд**- Тахианы баг /Гургуул/, Тагтааны баг / Тагтаа/, Боршувууны баг /Хэрээ, Болжмор, Боршувуу, Буулгат хөмрөг, Хөмрөг зэрэг 81 зүйл шувууд
- 2.3. **Махчин шувууд**-Харцагын баг /Явлаг, Харцага/, Шонхорын баг / Шонхор/ зэрэг 45 зүйл шувууд
- 2.4. **Дайран өнгөрдөг**-Монголд өндөглөдөг эсэх нь хараахан тодорхой бус 23 зүйл, хавар намар нүүдлийнхээ үед дайран өнгөрдөг-72 зүйл, өвлийн улиралд Тундр, Сибирээс орж ирж өвөлждөг-15 зүйл, Монгол оронд зусдаг, гэхдээ өндөглөдөггүй 21 зүйл шувууд
- 2.5. **Нүүдлийн шувууд**- Монгол оронд нүүдэллэн ирж өндөглөөд буцдаг 259 зүйл шувууд /энэхүү ангилалд усны шувууд болон зарим зүйлийн махчин шувууд орно/
- 2.6. **Тэжээвэр шувууд**- Ахуйн орчинд болон үйлдвэрийн орчин нөхцөлд тэжээж буй галуу, нугас, тахиа, бөднө, гургуул, цацагт хяруул зэрэг шувууд
- 2.7. **Идэвхигүй тандалт судалгаа** - Аман болон тоон мэдээ, мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх арга.
- 2.8. **Идэвхитэй тандалт судалгаа** - Шувуудын дунд хийгдэж, мэдээ мэдээлэл цуглуулах, сорьц цуглуулж шинжлэн, дүн шинжилгээ хийх арга хэмжээ.

### **ГУРАВ. ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ**

- 3.1. Тандалт судалгааны зааврын зорилго нь шувуунаас үүдэлтэй хүний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.
- 3.2. Зоонозын өвчин судлалын үндэсний төв болон аймаг, нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвүүд дагаж мөрдөнө.

### **ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

#### **4.1. Зоонозын өвчин судлалын үндэсний төв**

- 4.1.1. Шувууны томуугийн өвчлөлийн нөхцөл байдалтай уялдуулан эрсдэлийн үнэлгээг орон нутагтай хамтарч хийх, зөвлөмж боловсруулах;
- 4.1.2. Тандалт судалгааг бүхий л чиглэлд зохион байгуулж, эрсдэл өндөр газар нутгийг тодорхойлох
- 4.1.3. Шувуудын дунд тандах судалгааг тогтмол хийж эрсдэлд өртөх магадлал бүхий газар нутагт байнгын хяналтын үйл ажиллагааг сайжруулах
- 4.1.4. Зүй бус хорогдлын шалтгааныг тодруулах
- 4.1.5. Орон нутгийн иргэдээс асуумж судалгаа авах, хүн амын дунд тархвар судалгаан хийж, эрсдэлт хүчин зүйлийг тогтоон зөвлөмж зөвлөгөө хүргүүлэх
- 4.1.6. Шаардлагатай ус намгархаг газрын бүрэлдэхүүн хэсгийн төлөв байдалд үнэлгээ өгч, шаардлагатай тохиолдолд дээж авах,
- 4.1.7. Идэвхитэй тандалтын үед сангас түүх, амьд шувуудаас арчдас авах, өвчний сэжигтэй, үхсэн шувуудаас эд эрхтэний сорьц материал цуглуулж шинжилгээнд хамруулах,
- 4.1.8. Тандалтын бүх шатанд шинжилсэн сорьц материалын үр дүнг (эерэг, сөрөг) орон нутаг, болон холбогдох мэргэжлийн байгууллагуудад эргэн мэдээлнэ.
- 4.1.9. Эпизоотологийн холбогдлыг судлан дүгнэлт хийх
- 4.1.10. Аймаг, нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвүүдэд сургалт зохион байгуулах, ;

- 4.1.11. Голомтод бүс нутагт ажиллах үед нийт ажилчдын халдвар хамгаалалын дэглэмийг мөрдүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;
- 4.1.12. Тандалтын бүх хэлбэрт хүн амд зориулсан мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлэх, тогтмолжуулах;
- 4.1.13. Шувууны тандалт судалгааны календарчилсан төлөвлөгөөг хянах, санал, зөвлөгөө оруулах, ерөнхий захиралаар батлахуулах.
- 4.1.14. Үндэсний түвшинд шувууны тандалт судалгааны зааврыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих;
- 4.1.15. Тандалт судалгааны үр дүнг тайлагнах, илтгэл өгүүлэл бичиж нийтлүүлэх;
- 4.1.16. Тандалтын дүн мэдээгээр мэдээллийн сан үүсгэх

#### **4.2. Аймаг, нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв**

- 4.2.1. Шувуу олноор цуглардаг гол, нууруудын орчимд болон тогтоосон цэгт газарт усны шувуудын дунд зүйлийн бүрдэл, тоо толгойг гаргаж, тандалт хийх;
- 4.2.2. Тухайн орон нутагт шувуу зүй бусаар хорогдсон, сэжигтэй шувууд илэрсэн үед салбар шалтгааныг тодруулах, дээж авах, илгээх, мэдээлэх;
- 4.2.3. Тандалт судалгааг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэх;
- 4.2.4. Гол нуурын эргээр амьдардаг орон нутгийн иргэдээс мэдээлэл цуглуулж улиралд 1 удаа тухайн иргэдээс утсаар мэдээлэл авах, сэжигтэй тохиодол илэрсэн тухай бүр иргэд утсаар мэдээлэл өгөх харилцаа холбоог бүрдүүлэх, тандалтыг тогтмолжуулан, шуурхай мэдээг ЗӨСҮТ-ийн ШУН-д ирүүлэх;
- 4.2.5. Хүн амд зориулсан мэдээлэл, сурталчилгааг хийх;
- 4.2.6. Тандалт судалгааны үр дүнг тайлагнах, илтгэл өгүүлэл бичиж нийтлүүлэх;
- 4.2.7. Тандалтын явцад ус намгархаг газрын бүрэлдэхүүн хэсгийн (хөрс, ус, цаг уур) төлөв байдалд үнэлгээ өгөх, шаардлагатай тохиолдолд (шувууны зүй бус хорогдол бүртгэгдсэн) дээж материал авч шинжилгээ хийлгүүлэхээр илгээх

#### **ТАВ. АЖИЛЛАХ БҮРЭЛДЭХҮҮН, ШААРДЛАГАТАЙ БАГАЖ ХЭРЭГСЭЛ**

- 5.1. Тандалтын багт тархвар судлагч, амьтан судлагч 2-3, жолооч нар ажиллана.
- 5.2. Биоаюулгүй ажиллагааны шаардлага хангасан хамгаалах хувцас, хэрэгсэл, дуран /хүн бүр 10х50/, телескоп /80мм/, зургийн аппарат /1ш/, шувуудыг таних ном, гарын авлага /1ш/, шувууны тор /1ш/, сачок /1ш/, координат тодорхойлогч (GPS), шувуу тоологч эсвэл шувуу тоологч апплейкешен (counter UX) зэрэг байна. Сэжигтэй, үхсэн шувууд таарсан тохиолдолд сорьц цуглуулах вирус тээвэрлэх орчин бүхий цодонг хүрэлцэх тоогоор авна. Цуглуулсан сорьцийг хадгалах, тээвэрлэх шингэн азот (2 оос дээш өдөрт тээвэрлэх тохиолдолд) эсвэл машины хөлдөөгч зэрэг бэлтгэл хангасан байна. Задалгаа хийх болон бусад лабораторын багаж хэрэгсэлтэй байна.

#### **ЗУРГАА. ТАНДАЛТ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ**

Тандалт судалгааг дараах хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:

- Идэвхигүй тандалт судалгаа ;
- Идэвхитэй тандалт судалгаа;

#### **6.1. Идэвхигүй тандалт судалгаа**

- 6.1.1. Албан болон албан бус мэдээллийг шүүх, иргэдээс ирсэн мэдээллийг баталгаажуулах, ташаа мэдээллийг залруулах, удирдлагыг мэдээллээр хангах;

- 6.1.2. Хөрш зэргэлдээ орон болон Монгол орны шувууны зүй бус хорогдол, өвчлөлийн төлөв байдал, шилжилт хөдөлгөөн зэрэг мэдээллийг нэгтгэх, мэдээллийн сан үүсгэх (хавсралт 1);
- 6.1.3. Нийслэл болон орон нутгийн ЗӨСТ нь орон нутгийн шувуудын тооллого, бүртгэл хийж, шувуудын зүй бус хорогдол гэх мэт үйл явдлын мэдээг ЗӨСҮТ-ийн ШУН-д тогтмол мэдээлэх, мэдээллийн сан үүсгэх;
- 6.1.4. Тандалтын явцад орон нутгийн иргэдээс мэдээлэл авах ба тодорхой хугацааны дараа утсаар мэдээлэл замаар 2 дугаар тандалтыг хийнэ.


## 6.2. Идэвхитэй тандалт судалгаа

- 6.2.1. Шувуудыг тоолж бүртгэх, үхсэн болон өвчний сэжигтэй шувуудыг эрт илрүүлэх, сорьц цуглуулах (амьд, үхсэн, өвчний сэжигтэй шувууд, сангас, өд), сорьцийг түргэвчилсэн тест болон лабораторийн шинжилгээнд хамруулах/;
- 6.2.2. Усны шувууд, тэжээвэр болон суурин шувууд, махчин шувууд гэсэн 3 үндсэн чиглэлд тандалт судалгааг гүйцэтгэх;

### 6.2.2.1. Усны шувууны тандалт судалгаа

**Цэгэн тооллогын арга.** Энэ аргыг усны шувуудыг тоолоход хэрэглэх нь тохиромжтой бөгөөд тухайн нуурыг бүрэн харах боломжит цэгээс тандалт хийнэ. Томоохон нууранд 200 метр зайд 1 цэг байхаар хуваан тооллого хийнэ. Нэг бүрчлэн тоолж эхлэхээс өмнө нуурыг нэг захаас нөгөө зах хүртэл гүйлгэн харж тухайн нууранд олон тоогоор байгаа нэг зүйлийг эхэлж тоолно.

1-2 зүйлийг зэрэг тоолж болох ба тоологч эсвэл шувуу тоологч аппликейшн /Tally counter/ ашиглан 1,10,100-аар багцлан тоолно (зураг 1). Нэг нууранд нэгээс дээш баг ажиллах буй үед тооллогыг нэгэн зэрэг эхлэн, үргэсэн нисэж ирсэн шувуудыг тооллогод оруулах эсэхийг тооллогын сүүлд багаар ярилцаж шийднэ. Тухайн нууранд олон тоогоор байгаа шувууны зүйлийг эхлэж тоолно.




Зураг 1 Сүрэг шувуудыг багцлан тоолох

### 6.2.2.2. Махчин шувуудын тандалт судалгаа

**Замналын арга.** Тухайн газар нутгийн махчин болон суурин шувууг тодорхой цэгт ажиглах, зурвас газарт замналаар, явган эсвэл машин техникээр явганаар, хоёр тал (2 ажиглагч нэг нэг талыг хариуцан авч, 0-200 м хүртэлх зайд буй шувууг тодорхойлох) - д ажиглагдсан шувууг тоолж, замналын нийт туулсан зайг ажиглалт хийсэн хоёр талын 200 м, нийт 400 м талбайг тооцон тоологдсон шувуудын зүйл тус бүр дээр харьцангуй нягтшлиг тооцоолно.

**Шугаман маршрутын арга:** Зүйлийн элбэгшил, нягтшлиг тооцоолох арга юм. /Зураг 2/.



1. Өгөгдлийн цуглуулга

$L$  = маршрутын шугам

$Z$  = ажиглагчийн байршил

$X$  = ажиглаж буй объектийн байршил

$W$  = харагдацийн хязгаар (1/2)

$r_i$  = объект хүртэлх зай

$\theta_i$  (theta) = объектын харагдаж буй өнцөг

$y_i$  = перпендикуляр зай (тэмдэглэл  $y_i = r_i \sin \theta_i$ )

Зураг 2 Шугаман маршрутын арга

#### 1. Онолын үндэс:

- Тухайн талбайн бүх бодгалийг илрүүлэх шаардлагагүй.
- Объект багатай талбайн ирэх магадлал нь маршрутын уртын зайнаас хамаарна.
- Шугамын зай ихсэхэд, объектын хэмжээ багасдаг.

#### 2. Нягтшлиг үнэлэх

Томъёоны гаргалгаа  $g(x)$ -г ашиглан нягтшлиг ( $D^{\wedge}$ ) үнэлэхдээ:

$n$  = ажиглагдсан бодгалийн тоо

$L$  = маршрутын нийт урт

$w$  = харагдацын өргөн

$$\hat{D} = \frac{n}{2Lw}$$

Үүнээс хэрвээ  $w$  - г  $a$ - аар орлуулбал:

$$\hat{D} = \frac{n}{2La} \quad \text{Үүнд: } a = \text{үр ашигтай харгадацын өргөн}$$

### 6.2.2.3. Тэжээвэр шувууны аж ахуйд тандалт хийх

Өрхийн болон томоохон шувууны аж ахуйд урьдчилан бэлтгэсэн үнэлгээний хуудас (хавсралт 6) - ын дагуу авч дүгнэн, зөвлөмж өгнө. Тэжээвэр шувууд олноор эндсэн тохиолдолд хоол усны эх үүсвэр, орчны нөхцөл, тухайн орчинд хийгдсэн өөрчлөлт, өвчний эмнэлзүйн шинж тэмдэг зэргийг тэмдэглэнэ.

## **ДОЛОО. ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **7.1. Мэдээ цуглуулах, бүртгэх**

- 7.1.1. Тооллогын мэдээг анхан шатны бүртгэлд шувууны нэрсийн дагуу хайх замаар бүрэн гүйцэт оруулна (хавсралт 2).
- 7.1.2. Тандалтын үед нутгийн ард иргэдээс мэдээлэл цуглуулах, шувууны гаралтай өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, зөвлөгөө өгөх зэрэг тархвар судлалын ажлыг хамт гүйцэтгэнэ. (хавсралт 3).
- 7.1.3. Шувууны тандалт судалгаа, сорьц материал авсан бүх газарт экологийн ерөнхий судалгаа хийж гүйцэтгэнэ (хавсралт 4).
- 7.1.4. Шувууны томуугийн голомтын төлөв байдлыг тогтоох зорилгоор орон нутгийн шувууд цуглардаг томоохон гол, нуурт тодорхой цэгт газарт байнгын тогтмол цаг хугацааны давтамжтайгаар ажиглалт хийнэ (хавсралт 5).
- 7.1.5. Энэхүү цэгт газруудаас жил бүр өөрийн хүн хүчний хүчин чадал, санхүүд тохируулан сонгож, тандалт хийнэ.
- 7.1.6. Зайлшгүй тандалт хийх цэгүүдээс сонгож тандалт хийхдээ хүн амын суурьшлын бүсэд ойр, шувууд олноор цугладаг цэгүүдийг эхлэж сонгоно.
- 7.1.7. Шаардлагатай төлөвлөсөн цэгүүдийн байршилыг шинэчлэх боломжтой ба өөрчлөлт хийсэн тохиолдолд зааварт тусгана.
- 7.1.8. Шаардлагатай төлөвлөсөн тандалтын бүх цэгүүдээс ЗӨСҮТ нь шувууны тандалт болон бусад чиглэлийн /тахал, хачиг гм/ тандалтын явцад /зам дагуу байх/ тандалт хийнэ.

### **7.2. Өвчний сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед авах арга хэмжээ**

- 7.2.1. Эерэг гарсан тохиолдолд хариу арга хэмжээг авч, дахин сорьц авч баталгаажуулах ПГУ шинжилгээ /ЗӨСҮТ, УМЭАЦТ лаборатори/ хийлгэхээр хүргүүлнэ. Холбогдох бусад байгууллагад мэдээлнэ (Хавсралт 8).
- 7.2.2. Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллана.
- 7.2.3. Шувууд олноор үхсэн, өвчилсөн газар нутгийн байгаль орчны бүрэлдэхүүн хэсгийн өөрчлөлт (жнь: нуурын усны түвшин буурах, чанарт өөрчлөлт орсон бол шувууны ботулизм өвчин дэгдэх нөхцөл болох), дэд бүтэц зэрэг орчин нөхцөлийг тодорхойлон, зураг авч илтгэх хуудсанд хавсаргана.
- 7.2.4. Шувууны байранд халдвар бүртгэгдсэн тохиолдолд төмөр тор, тоног төхөөрөмж, байрны бетон шал болон шалны хөндлөвч, хог зайлуулах суваг, шувууны суултуур, тэжээлийн сав, услуур зэрэгт халдваргүйжүүлэлтийг холбогдох зааврын дагуу хийнэ.
- 7.2.5. Монгол оронд шувуудын дунд тохиолдох бүхий л өвчлөлийг шинжлэхийг зорих ба илрэх шинж тэмдэгээр урьдчилан тодорхойлж, сорьц материал авч, устгалын арга хэмжээ авна (Хавсралт 9).
- 7.2.6. Тандалтын явцад шувууд олноор үхсэн, өвчилсөн тохиолдол бүртгэгдвэл, илрэх шинж тэмдэг, гэмтэл, эд эрхтний өвчлөлийн байдлыг харгалзан үзэж эд эрхтэнээс боломжтой бол цуснаас сорьц материал авч шинжилгээнд илгээнэ. (Хавсралт 9).
- 7.2.7. Шувуунд задалгаа хийх үед аюулгүй ажиллагааны дэглэмийг дагаж мөрдөнө.
- 7.2.8. Эд эрхтэний дээж материал авахдаа гадаад дотоод үзлэг хийнэ.
- 7.2.9. Гадаад үзлэг: өд, паразит, гуужилт, шарх, нүх сүв байгаа эсэх
- 7.2.10. Дотоод үзлэг: Жавьжны орчмоор дээд эвэр хушууг тайрч хамрын болон дагавар хөндийнүүдийг үзнэ. Доод эрүүг тайрч цээжний урд тал хүртэл арьсыг зүснэ. Амны хөндийгөөс улаан хоолойг тасалж туушид нь цээжний урд тал хүртэл салгана.

Тагнай, залгиур хоолой, дууны төвөнхийг үзнэ. Мөгөөрсөн хоолойг залгиур хоолойноос эхлээд цээжний урд тал хүртэл тууш зүснэ. Мөгөөрсөн хоолойд паразит хорхой, мөөгөнцөрийн толбо, шүүдэс, гадны биет, цусны бүлэн байгаа эсэхийг шалгана. Цээжний урд талаас хойд тал хүртэл арьсыг зүснэ. Дунд чөмөгний тонгонцгийн үеийг салгана. Хэвлийн болон өвчүүний арьсыг хуулна. Арьс нь нягт барьцалдсан, мах нь харласан байвал ус дутсаны шинж байж болно. Цээжний булчинд хэд хэдэн огтлол хийж хувиралт байгаа эсэхийг тогтооно. Эгэмний болон бусад ясыг тэмтэрч хугаралттай эсэхийг шалгана. Өвчүүг хэвлийн булчин, хавирга, эгэм болон бусад яснаас салгана. Биеийн дотор хөндийг нээнгүүт цэвэр багаж хэрэгслээр эдийн шинэхэн дээжийг авна. Ингэхдээ бээлийтэй гараар эрхтэнд хүрэхээс өмнө дээж авна. Дараа нь эрхтнүүдийн байршил, ерөнхий байдлыг үзнэ. Ялангуяа хэвлийн хөндийд шингэн, паразит хорхой, буглаа эсвэл биет байгаа эсэхэд онцгой анхаарал тавина. Хэвлийн агаарын уут, үржлийн эрхтнүүдийг шинжлэх үүднээс ходоод, гэдсийг болгоомжтой гаргаж авна. Нян, түүний дотор *Chlamydomphila* төрлийн нянгийн халдварын үед гэдэсний гадаргуу, хэвлийн хөндийн ханан дээр ширхгэнцэр тогтсон байх нь олонтой. Зүрх, элэг, бусад эрхтний гадаргуу дээр цагаан шохой маягийн зүйл илрэх нь бөөрний үрэвслийн улмаас шээсний хүчил ихсэснээс тогтдог гол төлөв шээгний хүчлийн талст эсвэл ус дутагдсанаас үүсэх бөөрний өвчний үед ялгардаг шээгний хүчил байдаг. Зүрхний болон элэгний өвчин, хорын нөлөө эсвэл хавдрын улмаас хэвлийн хөндийд шингэн хуримтлагдаж болно. Агаарын уутны гадаргуу, мөгөөрсөн хоолойн дотор тал эсвэл уушгинд цагаан шаргал өнгийн хувирал үүсэх нь голдуу мөөгөнцрийн халдвар (аспергиллоз)-тай холбоотой байдаг ч нянгийн халдвар эсвэл хавдраас шалтгаалсан байж болно. Дэгдээхэйн хүй, өндгөн хоолойг шалгаж үзэн халдварын нөлөө байгаа эсэхийг тогтооно. Биеийн эд эрхтэнд үзлэг хийж эрхтэн бүрээс 0,5 см дээж авч 10 %-ийн буфержүүлсэн формалинд хийнэ. Хувиралттай хэсгээс нэг хэсэг дээж авч формалинд хийгээд нөгөө хэсгийг вирус өсгөвөрлөх ариутгасан цодонд хийх эсвэл эмгэг бие бүтцийн шинжилгээний хариу гартал хөлдөөж хадгална. Цусны эргэлтийн болон дархлааны тогтолцоонд үзлэг хийнэ. Зүрхний гол судаснуудыг угаар нь тайрч зүрхийг салгаж авна. Оройгоос нь эхлэн зүрхийг таллан зүсэхэд ховдлын хөндий, гурвалжин ялтсууд нь ил гарна. Шувууг үхэхийнх нь өмнө цус авч чадаагүй бол зүрхний ховдлоос тариураар цус соруулан авч түүнийгээ ийлдэсний хуруу шилэнд хийгээд цус бүлэгнэтэл байлгах, хэрэв хурилдуур байхгүй бол ийлдэс сайн ялгартал хүлээж дараа нь ийлдсийг цэвэр цодонд болгоомжтой юүлнэ. Мөгөөрсөн хоолойн салаалах тус газраар улаан хоолойг тасална. Хавчаараар улаан хоолойн төгсгөл хэсгээр хавчаад элэг, гэдсийг биеийн хөндийн дээд хэсэгтэй холбож байгаа хэвлийн хөндийн хальсыг тасдан улаан хоолойг салган авна. Элэг, гэдсийг хам сүвийн ар талд авч тавина. Гэдсийг хөвсөний дараа ийлдсэн бүрхүүлийн гадаргууг сайтар үзнэ. Нойр булчирхай, дэлүүг үзнэ. Нойр булчирхай нь боровтор өнгөтэй байх ба арван хоёр нугалаа гэдэсний өгсөх, уруудах гогцооны дунд орчим байрлана. Дэлүү нь элэг болон ходоодны гадна бүрхүүлийн хооронд, ходоодны булчинлаг, булчирхайлаг хэсгийн хоорондох нарийсалтын орчим байрлана. Элгийг хэвлийн хөндийн эрхтнүүдээс салгахын өмнө цөсний хүүдий эсвэл сувгийг шахах замаар цөсний суваг нээлттэй эсэхийг шалгана. Элгэнд хэд хэдэн зүсэлт хийж элэгний цуллагийн жигд байдал болон цөсний урсуурын тогтолцоог үзнэ. Задалгаа хийх бүртээ багаж хэрэгслээ спиртэнд дүрэх эсвэл дөлөөр ариутгана.

### **7.3. Шувууг таньж тодорхойлох**

- 7.3.1. Тандалт судалгаанд гарахаас өмнө тухайн бүс нутагт тархсан шувуудын зүйлийг урьдчилан судалсан байна.
- 7.3.2. Шувуудыг тодорхойлохдоо эхлээд овог, төрлөөр нь бүлэглэн ялгах хэрэгтэй. Жишээ нь: нугасыг галуунуудаас, шонхрыг бүргэдээс, чогчигыг цэгцгийнүүдээс ялгаж сурах нь хамгийн түрүүн эзэмшвэл зохих чадвар болно.
- 7.3.3. Дараа нь шувууны хэмжээ, өнгө зүс, зан төрх, зогсож байгаа байдал, нисэлт, амьдрах орчноор нь тодорхойлно.
- 7.3.4. Биеийн болон хошууны хэлбэр урт, хошууны ба толгойн уртын харьцаа, хөлийн тарс, сарвууны өнгө хэлбэр, сүүл далавчны хучуур өдний өнгө зэрэг онцлогыг нарийн ажиглан тогтоосноор шувууг зүйлийн түвшинд тодорхойлох боломжтой болно.

### **7.4. Тандалт судалгаанд анхаарах зүйл**


- 7.4.1. Шувуудыг таньж тодорхойлох, зураг авах, дээж материал авах зорилгоор шувуудад хавар буюу үржлийн үед нь хэт ойртохгүй байх;
- 7.4.2. Тандалт судалгааны эхлэх ба үргэлжлэх хугацааг тогтоохдоо улирлын цаг агаарын болон жилийн фенологийн нөхцөл, зэрлэг шувуудын экологийн онцлог зэргээс хамаарч хаврын улиралд 4 дүгээр сарын 15-наас 5 дугаар сарын 1-ний хооронд, намрын улиралд 9 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 1-ний хооронд сонгох;
- 7.4.3. Эхлэхээс өмнө тухайн газар нутгийн нуур, гол мөрөн орчмын бүс бүслүүр, байгалийн хэв маяг, хөрс ургамалжилтын газрын зургуудыг (1:500000, 1:100000) ашиглан гүйцэтгэх ажлын календарьчилсан төлөвлөгөө, байршил, маршрут зэргийг урьдчилан тодорхойлох ба тухайн нутагт байнга байршдаг шувуудын зүйлийн бүрдлийг урьдчилан тогтоох;
- 7.4.4. Биотоп тус бүрт тооллогын тохиромжтой хувилбарыг сонгон хамрагдах талбайн хэмжээг тухайн цэгт газраас шувууг бүрэн таньж тодорхойлох боломжтойгоор /дуран телескопны таталтын чадлаас хамаарч/ сонгох;
- 7.4.5. Зэрлэг шувуудын тооллогын хугацаанд чанга ярих, хурдан огцом хөдөлгөөн хийх, гүйж харайхыг хориглох ба цаг агаарын тааламжтай нөхцөлд, нар бүрэн мандсаны дараа өглөө эрт хийх;
- 7.4.6. Судалгаанд хамрагдсан нуур болон голын эрэг орчмын олон биотопуудыг хамруулан талбайн хайгуулыг гүйцэтгэж, маршрутаар тооллого явуулан үхсэн болон өвчтэй шувууд байгаа эсэхийг тогтоох;
- 7.4.7. Тандалт судалгааг хийхээс өмнө цаг агаарын урьдчилсан мэдээг авах;
- 7.4.8. Өрхийн болон томоохон шувууны аж ахуйд тандалт хийхдээ тухайн орчноос халдвар авахаас сэргийлэн мөн шувууны аж ахуйд өөрөө халдвар тараахаас сэргийлэн хамгаалах хувцас, хэрэгсэл буюу нэг удаагийн улавч, амны хаалт, бээлий хэрэглэнэ.

## **НАЙМ. БАРИХ, ТЭМДЭГЛЭХ, ДАХИН БАРИХ**

Шувуудад тэмдэглэгээ хийх замаар (хүзүүвч зүүх, бөгжлөх) шилжилт хөдөлгөөнийг тодорхойлох болон барьсан шувуудаас тандалтын сорьц авах ба сонгосон шувуудын төрөл зүйлээс хамаарч барих арга нь өөр өөр байна

### **8.1. Жижиг шувуудыг (*small passerines, song birds*) барих арга зүй.**

8.1.1. Суурин газрын ихэнх бор шувуу хэлбэртнийг барихдаа 16 мм босоо шувууны торыг ашиглаж болно (зураг 3). Торыг байршуулахаас өмнө тохиромжтой газрыг сонгох, мал, амьтан торыг гэмтээх аюул байгаа эсэхийг тогтооно. Торыг гуу жалга дагуу хөндлөн огтлуулж байршуулах ба 4 талаас гадсаар газарт татаж тогтооно.



Зураг 3 Жижиг шувууд барих тор

8.1.2. Тороор шувууг барихад анхаарах зүйлс:


- Торыг ойр ойрхон шалгаж байх ёстой ба 15-20 минутаас илүү хугацаанд орхиж болохгүй. Тогтмол хугацаанд шалгах боломжгүй үед торыг эвхэж, үлдээнэ.
- Торыг бороотой үед ашиглах нь шувууг гэмтээх, амархан үхэлд хүргэх аюултай.
- Салхитай үед торыг ашилахад шувууд торыг харах боломжтой болдог, мөн баригдсан тохиолдолд торны халаас бүхий хэсэгт унахгүй мултрах, гэмтэх аюултай.

8.1.3. Тороос шувууг салгаж авахад анхаарах зүйлс: үүнд

- Юуны өмнө шувуу торны аль талаас орсон байгааг шалгана.
- Шувууны их биеэс барьж хөлийг нэг нэгээр нь торноос салгана
- Аажуухан хумс, хөлийг салгаж дууссаны дараа их биеэр хөлийг хумиж зөв барина.
- Салгаж авахад хэцүү байсан ч сандарч болохгүй, салгаж авсаны дараа уутанд хийнэ.


## 8.2. Махчин шувуудыг барих арга зүй.

8.2.1. Доорхи аргуудаар бүх махчин шувуудыг барих боломжгүй тул шувуудын амьдрах орчин, зан төрхөд тохирсон тор, занга ашиглан барина. Шар шувуу, болон бусад махчин шувуудыг өгөөш ашиглан Bal-chatrri төрлийн тороор барина (зураг 4).



Зураг 4 Өгөөш бүхий махчин шувууны урхи

- 8.2.2. Өгөөш бүхий торны гадуур шувууны хөлөнд тээглэх гогцоо бүхий загасны сатуркан утсуудыг байрлуулна. Энэ төрлийн тор нь махчин шувууд харагдсан даруйд хурдан хугацаанд байршуулах боломжтой байдаг.
- 8.2.3. Махчин шувуудын үүрийг олсон тохиолдолд үүрний дэргэд энэ төрлийн торыг өгөөшгүйгээр суух газар нь байрлуулна. Мөн цахлай, гогой зэрэг бүлээрээ арал бүхий тодорхой нэг талбайд үүрлэдэг шувуудыг энэхүү аргаар өгөөшгүй барьж болно (зураг 5).



Зураг 5 Суух суудал, үүрний орчинд байршуулах өгөөшгүй урхи

- 8.2.4. Хаврын улиралд нүхэнд үүрлэж, хоргоддог шувуудыг холоос ажиглаж нүхнээс гарах хугацааг тооцоолж, нүхэнд орсоны дараа нүхний амсарыг тороор бүтээх байдлаар барина.

### 8.3. Усны шувуудыг барих

- 8.3.1. Галуутны багийн шувууд үржлийн үеийн дараа буюу 6-р сарын сүүл үеэс 7-р сарын дунд үе хүртэлх хугацаанд гуужиж, нисэх чадваргүй болдог тул энэ үед шувуудын завиар хөөж, эрэг дээр барьсан торон хашаанд оруулах замаар барьдаг.
- 8.3.2. Хун шувууг нуураас хөөж гарган эсвэл нууранд моторт завиар хөөх байдлаар нэг нэгээр нь барьж болно.

### 8.4. Шувууг тэмдэглэх

- 8.4.1. Барьсан шувуудыг тэмдэглэж байх нь дараах ач холбогдолтой. Үүнд:
- Шувуудын нүүдлийн чиглэлийг мэдэх боломжийг олгоно.
  - Нүүдлийн бус үед хэрэв нэг шувуу хоёр өөр газар баригдвал тухайн шувууны амьрах орчин, нүүдлийн замыг тогтоох боломжтой болно.
  - Тандалтын талбайд тухайн шувууны зан төрх, идэвхижил, хөдөлгөөнийг ажиглаж дүгнэлт хийх боломжтой болно.

- Нүүдлийн шувуудын баригдах магадлал буюу идэвхи голдуу өглөөгүүр 6:30-11:30 цагийн хооронд байдаг тул энэ үед шувууг барих ажлыг хийнэ.
- Зүйл болон зүүх бөгжний хэмжээг сонгохдоо Британийн шувуу судлалын сангийн (British Trust for Ornithology) гаргасан зааврыг дагана (Redfern and Clark 2001).
- Баригдсан шувуудыг ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн хаяг бүхий хөнгөн цагаан бөгжөөр бөгжилж тэмдэглэх, мөн олон өнгийн хуванцар бөгж хийж болно.

### ЕС. ШУВУУНЫ ҮҮРНЭЭС ШИМЭГЧ ТҮҮХ АРГА ЗҮЙ

- 9.1. Шувууны гадны шимэгчийг өд сөднөөс гадна үүрнээс түүнэ. Шувууны шимэгчид нь ихэвчлэн шувууны үүрэнд болон суудаг газарт үлдэж, шөнийн цагаар эзэн амьтныг шимэгчилдэг. Томруулдаг шилээр үүрийг самналтын аргаар нэг бүрчлэн авч шалгана.
- 9.2. Гадны шимэгчийг түүхдээ хямсаа, сойз, бийр ашиглаж хошууны уг, толгой, хүзүүг, өвчүү зэрэг шимэгч ихээр байх хэсгүүдээс зөөлөн самнаж авна.
- 9.3. Тандалтын явцад шувууны зан төрхийг сайтар ажиглаж, өөрчлөлт байгаа гэж үзвэл (шувууд нь өөрийгөө шимэгчээс хамгаалах аргууд болох хошуу болон хөлөөрөө шимэгчийг цэвэрлэх болно элс, шороогоор биеэ хучиж сэгсрэх, наранд биеэ ээх, шоргоолжоор шимэгчидийг түүж идүүлэх зэрэг зан төрхийг харж болно. ) шувууг барьж, самнаж үзэж болно.

### АРАВ. ШУВУУНААС СОРЬЦ АВАХ

- 10.1. Үхээд 24 цагаас хэтрээгүй 3 хүртлэх шувууны (олон шувууд үхсэн тохиолдолд) шинэхэн зэмийн дээж, боломжтой бол өвчтэй 3 хүртлэх шувууны дээж авахаас гадна өвчтэй шувуутай ойр шууд хавьталтай байсан ч эрүүл мэт харагдах 3 хүртлэх шувууны дээж тус тус авна.
- 10.2. Шувууны томуу өвчнийг оношлогоо шинжилгээний эцсийн үр дүн дээжийн чанараас ихээхэн хамаарах тул дээжийг оновчтой сонгон авч зөв хадгалах, тээвэрлэх нь маш чухал.
- 10.3. Хөврөлжүүлсэн өндөг, эсийн өсгөвөр халдаахад зориулсан дээж, вирус буюу нуклейн хүчлийг шууд илрүүлэхэд зориулсан дээжийг томуугийн шинж тэмдэг илэрснээс хойших эхний 3 өдөрт багтаан авах хэрэгтэй.
- 10.4. Шувууны томуугийн оношлогоо шинжилгээнд зориулж амьсгалын болон хоол боловсруулах замын аль алинаас дээж авна. Дээж бүрийг нэг дээж нэг саванд гэсэн зарчмыг баримтлана (Хавсралт 7).
- 10.5. **Дээж авахад бэлтгэх, хаяглах.** Томуугийн шинжилгээний дээжийн бүртгэлд дээж авсан газрын нэр, амьтны төрөл, дээжийн нэр, газарзүйн солбилцлийн дугаар, он сар өдрийг бичнэ. Дээжийн нэр буюу дугаарыг дээж хийсэн цодонгын гадна мөн тэмдэглэнэ.

Э= эрүүл, С= сэжигтэй, Ө= өвчилсөн, Ү=үхсэн

- 10.6. Дээжийн дагавар бичигт тухайн газар нутагт ямар төрөл, зүйлийн хэдэн шувуу байгаа, хоногт өвчилсөн болон үхсэн тоо, өвчний шинж тэмдэг хийгээд эмгэг хувиралт, анхны оношийн талаар тодорхой бичнэ.

#### **Амьд шувуунаас:**

- Багалзуур орчмын арчдас
- Төвөнх/ мөгөөрсөн хоолойн арчдас
- Төгсгөлийн сүвний арчдас
- Шувууны сангас
- Далавчны хураагуур судаснаас цус авна.

**Нядалсан буюу үхсэн шувуунаас:**

- Төвөнх /мөгөөрсөн хоолой/
- Уушиг, түүний гуурсны салс
- Тархи, нойр булчирхай, дэлүү
- Бүдүүн гэдэсний агуулагдахуун

**Дээж авахад шаардлагатай багаж, хэрэгсэл**

- Эргэдэг тагтай 1 - 3 мл - ийн цодон
- Полистер буюу модон иштэй ариун савх
- Эмгэг анатомын задалгааны багаж
- Вируст материал тээвэрлэх орчин
- Цусны хуруу шил, зүү
- 3 мл-ийн тариур
- Хурилдуур

**10.7. Дээж авах аргачлал.**

Шувуунаас дотор эрхтний дээж авахдаа хайч, хямсаа, мэс заслын хутга зэрэг ариу багажууд болон жижиг цодонг сэрэглэнэ. Амьтдыг задлахын өмнө халдваргүйтгэх уусмалд (5%-ийн хлорамин) - нд 20-30 секунд дүрнэ. Эрхтний дээж авахдаа задлах хэсгийг урьдчилан 5%-ийн иодын уусмал эсвэл 70% -ийн этилийн спиртээр арчиж, ариун багажийг хэрэглэнэ.

- Багалзуур орчмоос арчдас авах: Шувууны амыг ангайлгаад хуурай ариун бойтуураар багалзуурын арын хэсгийн хоёр талыг ээлжлэн арчих буюу хэд хэдэн удаа эргүүлэн арчдас авна. Арчдас бүхий бойтуурыг тээвэрлэх орчинтой цодод хийж үзүүрийг нь хугалж дотор нь үлдээгээд таглана.
- Төвөнх / мөгөөрсөн хоолойноос арчдас авах Доод эрүүний завсар орших төвөнхийн ховилоор ариун бойтуурны хөвөн үзүүрийг шургуулж арчих аргаар авч тээвэрлэх орчинд хийнэ. Үхсэн, нядалсан шувууны мөгөөрсөн хоолой, уушигны гуурснаас мөн адил аргаар арчдас авч болно.

Багалзуураас авах




Хойд сүвний арчдас



Бойтуурыг хугалах



Дээжийн хаяг




Зураг 6 Шувуунаас дээж авах арга

- Хойт сүвнээс арчдас авах Ариун бойтуурыг хойт сүвэнд гүнзгий шургуулж эргэлдүүлэх болон нааш цааш холхиулах маягаар арчдасыг авна. Энэ тохиолдолд ариун бойтуурны хөвөнд баасны эдийг сайн шингээх нь чухал ба бойтуурын арчдас бүхий үзүүрийг цодонд хийж хугалж үлдээгээд хаяглана. Ариун савхны үзүүрийн хөвөнг багасгах эсвэл жижиг шувуунд зориулж жижиг савх авах
- Сангасны дээж авах Шувууны шинэхэн нойтон сангасыг ариун бойтуураар арчин шингээгээд цодонд хийж хаяглана.
- Эдийн дээж авах Үхсэн буюу нядалсан шувууны тархи, нойр булчирхай, дэлүү, уушиг, элэг, мөгөөрсөн хоолой, түүний гуурсны салс, бүдүүн гэдэсний хэсгээс жижиг хэрчим авч хөлдөөх буюу тээвэрлэх орчинд хийж тээвэрлэнэ. Хөлдөөх боломжгүй бол хоёр хоногийн дотор лабораторид хүргэнэ. Эдийн жижиг дээжийг тээвэрлэх орчинд цийдмэгжүүлнэ /Зураг 9/.
- Томууг оношлох ба тандах шинжилгээнд ийлдэс цуглуулах Сул хоруу чанартай вирусээр халдварласан шувууг оношлох, мөн вирус тээгч шувууг илрүүлэх зорилгоор тандах шинжилгээнд зориулж тэжээвэр шувууны далавчны хураагуур судаснаас 3 мл-ийн тариураар цус авна. Нядалж байгаа болон зэрлэг шувуунаас тандал шинжилгээнд ийлдсийг цуглуулахдаа цусыг авч ийлдсийг ялгах нь сайн. Үүний тулд авсан цусаа 2500 эргэлтээр 15 минут эргүүлж ийлдсийг ялгана. Ийлдсийг -20°C - д хадгална.

#### Цус авах судаснууд:

- Хүзүүний бүдүүн артерын судас
- Далавчны хураагуур судас
- Тарсны судас
- Гуя орчмын судас /Зураг 7/.



Зураг 7 Шувуунаас цус авах судасны байрлал

10.8. Ийлдэсний дагалдах хаягт он, сар, өдөр, газар нутгийн нэр, амьтны зүйлийн нэр, эрхтний дээжийн нэр, газар зүйн солбилцол, цуглуулсан хүний нэрийг заавал бичнэ.

#### 10.9. Дээж хадгалах, тээвэрлэх.

Судалгааны үед агнасан, олсон шувуу тус бүрийг нягт даавуугаар хийсэн уутанд хийж, амсрыг 2 эргүүлж, нугалан хаягийг хавчуулан сайн боож тээвэрлэхдээ давхар хулдаасан уутанд хийнэ. Шувуунаас авсан арчдас, эд эрхтний дээжийг шинжлэхийн өмнө +4°C-д эсвэл мөсөн хавтантай хөргүүрт хадгалж болдог. Хөдөө хээрийн нөхцөлд ажиллаж байгаа үед тасалгааны хэмд хадгалаж болохуйц вирус тээвэрлэлтийн орчин эсвэл шингэн азоттой дьюар саванд хийж хөлдүүгээр нь хадгална. Хэрэв дээжийг 24 - 48 цагийн дотор лабораторт хүргэхээр бол мөстэй

хавтанцартай саванд хийж тээвэрлээд хөргөгчинд хадгалж болно. Харин дээрхээс илүү хугацаагаар хадгалахаар бол тухайн дээжийг -70°C – ын хөлдөөгч эсвэл шингэн азотод (хийхдээ хасах хэмд тэсвэртэй хуванцар бичил, эргэдэг тагтай хуруу шил ашиглана) хадгална. Вирус нь хөлдөөж, гэсгээх явцад таньцаа амархан алддаг тул тухайн дээжийг зөвхөн нэг л удаа хөлдөөж гэсгээнэ. Глицеринтэй орчин нь дээжийг хүйтэнд удаан хадгалахад тохиромжтойн зэрэгцээ энэ орчинд хадгалсан дээжээр өндөг халдаахад зохимжтой. Харин эдийн өсгөвөр халдаах, иммунохроматограф, иммунофлуоресценцийн шинжилгээ хийхэд зохисгүй. Иймд дээжийг тээвэрлэх орчинтой болон орчингүй 2 цод давхар авах нь тохиромжтой. Харин дээжийг хуурай мөстэй тээвэрлэх бол дээжээ агаар орохооргүй саванд хийж наалдамхай туузаар сайн ороож давхар уутанд хийнэ. Хэрэв дээжинд CO<sub>2</sub> нэвчвэл шувууны томуугийн вирус идэвхээ алдаж лабораторийн шинжилгээний шаардлага хангахгүй болно. 1-4 зэргийн эмгэг төрөгч бичил биетийг бүртгэх, хадгалах, шилжүүлэх, тээвэрлэх журмын хүрээнд аюулгүй байдлыг хангаж тээвэрлэнэ.

### **АРВАН НЭГ. ТАЙЛАН БИЧИХ ДАРААЛАЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 11.1. Тархвар судлагч, амьтан судлагч нар нь тандалт судалгааны үр дүнг өмнөх жилийн болон 5 жилээр харьцуулан дүгнэлт гаргаж, цаашид анхаарах асуудалыг тодорхойлон анхан шатны бүртгэл маягтыг хавсарган ЗӨСҮТ-д цахимаар болон цаасаар (10,11-р сар) ирүүлнэ.
- 11.2. Дүгнэлт хийхдээ:
  - Нэг цэгт шувуудын зүйлийн тоо цөөн боловч олон тоогоор тоологдох нь цаашид халдварт өвчин шувууд хооронд дамжих эрсдэлийг нэмэгдүүлэх;
  - Олон зүйл шувууд тоологдох нь тухайн уст цэг байгалийн тэнцвэрт байдлаа алдаагүй гэж үзэх;
  - Шаазгай, хэрээ, элээ, тагтаа зэрэг шувууд олноор тоологдох нь тухайн орчинг бохирдсон гэж үзэх;
  - Хэрээ, тас зэрэг шувууд олноор тоологдсон тохиолдолд тухайн орчинд амьтдын зүй бус хорогдол байгаа эсэхийг шалгах;
  - Анхан шатны бүртгэлийг шивэн, боловсруулалт хийж, дүгнэх;
  - Тухайн орон нутгийн нүүдлийн шувуудын ирэх буцах хугацааг тодорхойлох;
- 11.3. Шуурхай мэдээг 14 хоногт багтаан ирүүлэх ба мэдээнд нийт тандалтын маршрут, ажилласан бүрэлдэхүүн, өвчний сэжигтэй, үхсэн шувууд тохиолдсон эсэх, нийт тоологдсон шувуудаас өвчинд өртөмтгий шувуудын тоо, асуумж судалгаа авсан иргэдийн мэдээ зэргийг тусгана.
- 11.4. Тандалтын мэдээг нэгтгэн мэдээллийн сан үүсгэх ба мэдээллийн сан дээр үндэслэн улирал, жилээр нягтшил, тархалтын зураг гаргана.

## АРВАН ХОЁР. АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

- 10.1. “Зэрлэг шувуунд өндөр хоруу чанартай шувууны томууг тандан судалгаа” гарын авлага
- 10.2. “Хээрийн шинжилгээний арга зүй” ЗӨСҮТөвийн бүтээл 2005 он
- 10.3. “Монгол дахь шувуудад чухал газрын лавлах” (Нямбаяр.Б,Н.Цэвээнмядаг 2009).
- 10.4. ЗӨСҮТ, ОХУ-ын Новосибирск хотын Вируслоги, биотехнологи судлалын үндэсний “Вектор” төвтэй хамтран 2003-2009 онд хийсэн шинжилгээгээний тайлангууд.
- 10.5. “Шувуу судлах хээрийн судалгааны анхан шатны арга зүй” С.Бархүү (БОАЖЯ), Н.Цэвээнмядаг (Биологийн хүрээлэн). 2009 он
- 10.6. “Шувууны томуу өвчний тандалт хийх заавар” УМЭАЦТөв лаборатори
- 10.7. “Шинээр гарч буй болон дахин сэргэж буй зарим халдварт өвчний Монгол дахь экологийн орчлын судалгаа” Гоц 1 төслийн 1,2-р боть
- 10.8. “ОУ-ын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноороо амьдардаг орчны тухай *Рамсарын конвенц*” 1971 он
- 10.9. *Capture Techniques*, Peter H.Bloom, William S. Clark, Jeff W. Kidd
- 10.10. Avian Influenza, Fowl Plague, Grippe Aviaire
- 10.11. A Field Manual for the Study of Wild Birds, A.B.M Sarowar Alam, Kazi Zenifar Azmiri, Sakib Ahmed, Md. Ziaur Rahman
- 10.12. Байгалийн голомтот халдварт өвчний лабораторийн оношлогооны протокол, 2010 он
- 10.13. Centers for Disease Control and Prevention (CDC)  
<https://www.cdc.gov/flu/about/index.html>
- 10.14. Зоонозийн халдварт өвчний үед ажиллах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн заавар, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 04-р сарын 21 ны өдрийн А/161/ дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт

### Хавсралт 1 Шувууны томуу өвчний тохиолдол тархалтын мэдээ

|                                       |                                                                                                                |                     |
|---------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|
| Төлөв байдлын мэдээ гаргасан ажилтан: |                                                                                                                |                     |
| Огноо:                                |                                                                                                                |                     |
| Хамрах хүрээ:                         |                                                                                                                |                     |
| <b>№</b>                              | <b>Дэд хэвшинж</b>                                                                                             | <b>Төлөв байдал</b> |
| 1                                     | Шувууны томуугийн А хүрээний вирусн шувууны өвчлөлийн хураангуй мэдээлэл:                                      |                     |
| 2                                     | Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусн хүний өвчлөлийн болон бусад амьтдын өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл: |                     |
| 3                                     | Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:                               |                     |
| 4                                     | Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:                               |                     |
| 5                                     | Шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:                               |                     |
| 6                                     | Шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:                               |                     |
| 7                                     | Шувууны томуугийн А хүрээний (H5N8) вирусн хүний болон бусад амьтдын өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:           |                     |
| 8                                     | Шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн хүний болон бусад амьтдын мэдээлэл: (Хүснэгтээр, зургаар)       |                     |
| 9                                     | Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдлын мэдээлэл:                                       |                     |

## Хавсралт 2 Шувууны тандалт судалгааны бүртгэл

|                                                                 |                |                      |                                                      |
|-----------------------------------------------------------------|----------------|----------------------|------------------------------------------------------|
| Аймаг:                                                          | .....<br>..... | <b>Салхины хурд:</b> | 1 балл - салхигүй                                    |
| Сум:                                                            | .....<br>..... |                      | 2 балл - сэвэлзүүр зөөлөн                            |
| Газрын /цэгийн/ нэр:                                            | .....<br>..... |                      | 3 балл - дунд зэрэг хүчтэй, , дээлийн хормой дэрвэнэ |
| Газарзүйн солбилцол:                                            | .....<br>..... |                      | 4 балл - хүчтэй, модны мөчир найгана                 |
| Амьдрах орчин:                                                  | .....<br>..... |                      | 5 балл - ширүүн салхи, модны мөчир савлана           |
| Тооллогын цэгийн харагдац (м)                                   | .....<br>..... | <b>Үүлшилт:</b>      | 1 балл - 0-5%, цэлмэг                                |
